



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2025 оны 08 сарын 20 өдөр

Дугаар 129.

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 183ШШ/2020/02850 дугаар захирамж, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 183ШЗ/2021/02854 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн Y-1817003237 дугаартай, Хэнтий аймгийн Хэрлэн сум, 4 дүгээр багт байрлах Сариг А38 дугаар байрны 40 тоот, 30.34 м.кв талбайтай, нийт 38,607,000.00 (гучин найман сая зургаан зуун долоон мянга) төгрөгийн үнэлгээ бүхий нэг өрөө орон сууцны байрыг шүүхийн шийдвэрийн дагуу авлагад тооцон төрийн өмчид хүлээн авч, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Н.Нандинболор нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Төрийн өмчид хүлээн авахаар шийдвэрлэсэн хавсралтад заасан орон сууцны байрыг хүлээлцэх ажлыг Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгө, өр төлбөрийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3.Энэ шийдвэрийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлж, өмнөх өмчлөгчийн нэр дээрх өмчлөгчийн эрхийн гэрчилгээг хүчингүй болгуулах, төрийн өмчид бүртгэх ажлыг зохион байгуулж арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132000421

7-r huraldaan.docx